

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ  
2022 ОНЫ 4 ДҮГЭЭР САРД БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖИЛ**

2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№	Хийсэн ажил /чиглэлээр/	Гүйцэтгэсэн ажлын төрөл дараахь 4-н аль нэгийг сонгож (✓) тэмдэглэгээ хийх			
		Тулгамд- сан ажил	УИХ, ЗГ-г өргөн барьсан	Салбарын хүрээнд хийгдсэн	Шинэлэг ажил
<b>I</b>	<b>Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр</b>				
1.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулахаар ажиллаж байна. Энэ хүрээнд дэд ажлын хэсгийн дарга Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, олон улсын зөвлөхүүдийг хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр дэд сайд С.Зулпхар нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулах ажилд дэмжлэг үзүүлж байгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагад талархал илэрхийллээ.			✓	
2.	Нийгмийн халамжийн сангийн улсын төсвийн санхүүжилтийн 2023 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах саналд халамжийн сангийн төсвийн танилцуулга болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх тооцоо судалгаа боловсруулав.			✓	
3.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас боловсруулан ирүүлсэн дараах журам болон бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөв. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• “Цахим үндэстэн” дунд хугацааны бодлогын баримт бичиг</li> <li>• Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам</li> <li>• Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар</li> <li>• Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах, ашиглах журам</li> <li>• Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнөх үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журам</li> <li>• Мэдээлэл, хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэг журам</li> <li>• Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам</li> <li>• Хүн, хуулийн этгээдэд, цаасан хэлбэрээр мэдээлэл өгөхтэй холбогдон гарах зардал тооцох аргачлал, зардлыг төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам</li> <li>• Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэлийн журам</li> <li>• Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт, үнэлгээ хийх журам</li> <li>• Цахим хуудас хөтлөх, ил тод нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам</li> <li>• “Цахим ур чадвар, боловсролыг дэмжих” дунд хугацааны төлөвлөгөө</li> <li>• Нээлттэй өгөгдлийн төлбөр тооцох аргачлал</li> <li>• Онц чухал мэдээллийн дэд бүтэц бүхий байгууллагын жагсаалт</li> </ul>			✓	
4.	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсний дараа УИХ-аас Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж, Засгийн газраас 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авч байгаа тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг 15-43 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500.0 мянган төгрөгт, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 400.0 мянган төгрөгт тус тус хүргэсэн. Энэхүү арга хэмжээ нь тэтгэврийн даатгалын сангийн ачааллыг нэмэгдүүлсний улмаас УИХ-д өргөн мэдүүлсэн багц хуулийн төсөлд тусгасан зарим зүйл,				

	заалтыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүсэхээр байгаа тул хууль санаачлагчийн зүгээс Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийг тус тус хэлэлцүүлгээс татан авч, үүссэн нөхцөл байдалд нийцүүлэн дахин боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр болсон. Иймд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу дахин боловсруулж, хуулийн төслүүдийн үр нөлөөний, зардлын тооцооны судалгааг дахин боловсруулж, үзэл баримтлалын төслийг ХНХ-ын сайд, ХЗДХ-ийн сайд нар хамтран батлаад байна.			√	
5.	Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгаа болон хуулийн үзэл баримтлалын төслүүдийг дахин боловсруулж, Засгийн газрын гишүүд, СЗХ, МҮЭХ, МАОЭНХ зэрэг байгууллагуудаас санал авахаар 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 01/1127 дугаар албан бичгээр хүргүүлэв.			√	
6.	Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэх гэж байгаатай холбогдуулан “Нийгмийн даатгалд даатгуулсан зарим иргэнд дэмжлэг үзүүлэх тухай” хуулийн төслийг боловсруулан 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Сангийн яаманд хүргүүлэв. Хуулийн төсөлд нэг сая ба түүнээс доош нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлоготой даатгуулагчид түүний 2022 оны 5-12 дугаар сард өөрөө хариуцан төлсөн тэтгэврийн, тэтгэмжийн, ажилгүйдлийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн дэмжлэгийг олгохтой холбоотой зохицуулалтыг тусгасан.			√	
7.	“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэх Шинжээчдийн түвшний 3 дахь удаагийн хэлэлцээг 2022 оны 4 дүгээр сарын 4-5-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулав. Хэлэлцээний үеэр шинжээчдийн баг хэлэлцээрийн төслийн бүх заалтыг болон талуудаас гаргасан саналыг хэлэлцэн тохиролцсон бөгөөд холбогдох өөрчлөлтийг төсөлд тусгаж эцэслэн боловсруулав. Уг хэлэлцээрийн төслийн англи хэлээрх хувилбарыг эцэслэн 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдөр гэхэд харилцан солилцохоор тохиролцов.			√	
8.	Хуримтлалын нэгдсэн сан байгуулах ажлын хүрээнд Сингапур Улсын туршлагыг судлах, хуримтлалын нэгдсэн сангийн тогтолцоог Монгол Улсад нэвтрүүлэх зорилгоор Сингапурын хамтын ажиллагааны байгууллага (SCE)-тай 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр онлайн уулзалт зохион байгуулав. Уулзалтын үр дүнд Монгол Улсад Хуримтлалын нэгдсэн сан бий болгоход дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний төслийн үзэл баримтлалыг боловсруулж Сингапур Улсын талд хүргүүлэв.				√
9.	2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/103 тоот тушаалаар батлагдсан Хүнсний эрхийн бичиг олгох журмын холбогдох зарим заалтад өөрчлөлт оруулахаар тооцоо судалгааг хийж танилцуулга бэлтгэв.			√	
10.	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5 дахь заалтад гадаад ажиллах хүч, мэргэжилтний ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх гэж заасны дагуу Засгийн газрын 2022 оны 80 дугаар тогтоолоор “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх” журамд нэмэлт оруулан эрх зүйн орчныг бүрдүүлсний дагуу аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлж эхлээд байна.			√	
11.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн А/162 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, хуулийн төслийг Улсын Их Хуралд 2022 онд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. Хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд хуулийн бичвэр томъёоллыг боловсруулж, хөдөлмөрийн салбарын ажилтнуудын төлөөллүүдээс санал авах ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 4-8-ны өдрүүдэд зохион байгуулав. Энэ ажилд давхардсан тоогоор нийт 40 гаруй албан тушаалтан оролцож, 50 гаруй санал гаргасан байна.			√	
12.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд орсон өөрчлөлттэй холбоотой үзэл баримтлалын төсөл, хуулийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааны төслүүдийг сайжруулан ажиллаж байна. Түүнчлэн хуулийг хэрэгжүүлэхэд үүсэх зардлын тооцоог дахин хийлгүүлэхээр хуулийн төсөлд орсон зардлын тооцоотой холбоотой			√	

	мэдээллийг бэлтгэж байна.				
13.	Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг үзэл баримтлалын төсөл болон холбогдох баримт бичгийн хамт Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд хуулийн төсөл болон үзэл баримтлалын төслийг холбогдох төрийн бус байгууллагын төлөөлөлд хэлэлцүүлэв.			√	
14.	Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч хөдөлмөр эрхлээгүй байгаа эх /эцэг/-ийн Эрүүл мэндийн даатгал болон Нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс бүрэн хариуцах хуулийн төсөл болон танилцуулгыг боловсруулав.			√	
15.	-Хурдан морины уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллах ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, Баяр наадмын тухай хуулийн төсөл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл, хурдан морины уралдааны дүрэмд оруулах саналыг танилцуулав. -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/190, А/280 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ын нэмэлт, өөрчлөлтийг батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэв.			√	
16.	“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх заавар”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/57 дугаар тушаалаар батлав. Энэхүү заавар нь хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх, холбон зуучлах үйлчилгээнд хамруулахад арга зүйн заавар өгөхөд чиглэнэ.			√	
17.	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар батлууллаа.			√	
<b>Бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр</b>					
18.	Нийгмийн халамжийн тогтолцооны өнөөгийн байдал, хууль тогтоомжийн шинэчлэлийн талаар иргэд, олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор Монгол HD телевизтэй хамтран 2 нэвтрүүлэг бэлтгэх хүрээнд нэвтрүүлгийн агуулга, ярианы сэдэв, оролцогсдын жагсаалтыг бэлтгэн, оролцогсдыг яриа өгөх цагийн хуваарь, орчин нөхцөлийг бүрдүүлж өгч ажиллав. Зураг авалтыг 4 дүгээр сарын 11-18-ны өдрүүдэд хийж, өрх, иргэд, дүүрэг, агентлагийн дарга, мэргэжилтнүүдийг оролцуулав. Яамны сайд, дэд сайд, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, мэргэжилтнүүд бэлтгэсэн агуулгын хүрээнд холбогдох мэдээлэл өгч хамтран ажиллав.			√	
19.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн нийгмийн халамж, түүний эрх зүйн орчны талаар Өнөөдөр сонины “Редакцын уулзалт”-ын хэлэлцүүлэгт Бодлого, төлөвлөлтийн газрын асуудал хариуцсан ахлах шинжээч оролцож манай улсын нийгмийн халамжийн системийн өнөөгийн нөхцөл байдал ямар байгаа, түүнийг хэрхэн сайжруулах, хууль, эрх зүйн орчныг шинэчлэх хүрээнд хийгдэж байгаа ажлын талаар мэдээлэл өгөв. Хэлэлцүүлгийн мэдээлэл Өнөөдөр сонины 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн дугаарт нийтлэгдэв.			√	
20.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Нийгмийн халамжийн тухай хуульд заасан Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох асуудалтай холбоотой хоёрдмол зүйл, заалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газарт чиглэл хүргүүлэв.			√	
21.	“Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд Тогтвортой хөгжлийн зорилго, Алсын хараа-2050, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын уялдааг гаргахаар ажиллаж байна. Бодлогын баримт бичгийн уялдааг гаргаснаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2023-2025 оны төсвийн төлөвлөлтийг оновчтой төсөвлөх, төлөвлөх, хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдолтой юм.			√	
22.	“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг бэлтгэн Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтод 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 01/997 тоот албан бичгээр хүргүүлэв.		√		

23.	Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан L4052 дугаартай зээлийн хэлэлцээрийн дагуу тус яамнаас “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2”-ын хүрээнд Төгсөлтийн аргачлалаар туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.			√	
24.	Японы хамтын ажиллагааны нийгэмлэг ЖАЙКА-ийн удирдлагуудтай ХНХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга уулзаж, Нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах болон цаашид хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаар санал солилцож хамтран ажиллах чиглэлээ тодорхойлов.			√	
25.	Гадаад зөвлөхийн Орлогыг орлуулан тооцох аргачлалын туршилтын судалгааны үр дүнд тооцоолол хийсэн мэдээллийг хүлээн авч танилцаж, ХХҮЕГ-ын аймаг, дүүргийн газар, хэлтэс болон судалгааны байгууллагын туршилтын судалгаанаас гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн боловсруулж дэд ажлын хэсгийн хүрээнд хуралдаж гарсан санал болон ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын саналыг тусгаж аргачлалын төслийг эцэслэн ҮСХ-нд 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 01/1045 тоот албан бичгээр Арга зүйн байнгын зөвлөл болон даргын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хүргүүлэв. Үүний дагуу Арга зүйн байнгын зөвлөлөөс аргачлалд ирүүлсэн саналыг тусган тус зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дэмжигдэн даргын зөвлөлд танилцуулахаар болсон.			√	
26.	Төв аймгийн Батсүмбэр сум дахь Ахмад настны үндэсний төвийн бүтэц, орон тоо, дүрмийг шинэчлэн боловсруулах, эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлд хамруулахад бэлтгэх зорилгоор мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ХНХС-ын 2022 оны А/60 дугаар тушаалаар, Ахмад настны үйлчилгээг цахимжуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ХНХС-ын 2022 оны А/61 дүгээр тушаалаар тус тус байгуулан ажлын хэсгийн хурлыг зохион байгуулсан.			√	
27.	НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Жирэмсэн эхэд зориулсан цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллын туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудыг мэдээллээр хангах, хамтын ажиллагааг уялдуулах, үр шимийг хүртэгчдэд зөв ойлголт, мэдээлэл хүргэх, ач холбогдлыг таниулах ажлыг хэрхэн зохион байгуулах, хэрэгжилт, үр дүнг хэрхэн үнэлэх зэргийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалттайгаар хийх арга зүйг олгох зорилгоор сумын хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, сумын Эрүүл мэндийн төвийн эмч нарт зориулсан сургалтыг 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Завхан аймагт, 4 дүгээр сарын 18-ны өдөр Баянхонгор аймагт тус тус зохион байгуулав.			√	
28.	Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг, хөнгөлөлт олгох журам”-ын 2.5, мөн тус тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 2.17, Засгийн газрын 2021 оны “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ шинэчлэн батлах тухай” 363 дугаар тогтоолын дагуу Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусгай хэрэгсэл нийлүүлэх байгууллагын жагсаалт гаргах ажлын хэсгийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 05-ний өдрийн А/04 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/17 дугаар тушаалаар батлагдсан “Протез, ортопед, тусгай хэрэгсэл захиалгаар хийх, нийлүүлэх байгууллагын жагсаалтад орох байгууллагад тавигдах шалгуур”-ын дагуу 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр байгууллагын албан ёсны hudulmur-halamj.gov.mn цахим сайтад зар тавьж, 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдөр хүртэл 30 хоног хугацаанд 58 байгууллагын материал хүлээн авч үнэлгээ хийсэн. Үүнээс 17 байгууллага батлагдсан шалгуурын шаардлага хангаагүй тул жагсаалтад оруулахаас татгалзаж, шалгуур хангасан захиалгаар хийх 13 байгууллага, нийлүүлэгч давхардсан тоогоор 41 байгууллагатай гэрээ байгуулахаар шалгаруулаад байна.			√	
29.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хүмүүнлэгийн чиглэлээр хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, жил бүр хамтран ажиллах гэрээ, төлөвлөгөө батлан ажиллаж байна. Энэ хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Ахмад настны үндэсний төвийн асруулагчид, ажилтан, албан хаагчдад нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, амьдрах ухааны сургалт, арга хэмжээг зохион байгууллаа. <b>/2022 оны тухайд МУЗН-тэй 59.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан/</b>			√	
30.	Монгол Улсын Засгийн газар ЖАЙКА байгууллагатай хамтран “Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоо бэхжүүлэх төсөл”-ийг 2021-			√	

	2025 оны хооронд хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байранд нь дадлагажуулах хүний нөөцийг бэхжүүлэх тогтолцоо бүрдүүлэх бөгөөд эрх зүйн орчныг бий болгох зорилгоор “Ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагааг зохицуулах удирдамж”-ын төслийг боловсруулан холбогдох төрийн бус байгууллагын төлөөлөлд хэлэлцүүлж, санал аван батлуулахаар ажиллаж байна.				
31.	Эрүүл мэндийн сайд, ХНХ-ын сайдын “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамж шинэчлэн батлах тухай” 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/231, А/77 дугаар хамтарсан тушаал батлуулав.			√	
32.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасан нийгмийн нөлөөллийн үнэлгээний журам, аргачлалын төслийг БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга, холбогдох ажилтнуудад танилцуулав. БОАЖЯ-аас боловсруулж буй журам, аргачлалын төслийг шинэчлэн боловсруулж байгаа ба төслүүдийг нэгтгэн боловсруулахад талууд ойрын хугацаанд хамтран ажиллахаар тохиролцов.			√	
33.	ЭЗНСЭТухай ОУ-ын пакт, түүний нэмэлт протоколын хэрэгжилт, үүнтэй холбоотой хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал зөвлөмж, илтгэлийн төслийг боловсруулав.			√	
34.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн дүрмийг шинэчлэн батлах тухай ХНХ-ын сайдын тушаалыг батлуулан холбогдох газарт хүргүүллээ.</li> <li>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэх тухай ЗГТ-ын төсөл эсвэл Ерөнхий сайдын захирамжийн төслийг боловсруулж байна.</li> <li>Дэд сайдын ахалсан нийгмийн халамжийг зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцүүлж, амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглүүлэх, үйлчилгээний нэр төрлийг оновчтой тогтоох, чанар хүртээмжийг сайжруулах санал, дүгнэлт боловсруулан хэрэгжүүлэхээр байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд нийгмийн халамжийн бодлогоор дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих тухай олон улсын туршлагаас өөрийн оронд нэвтрүүлэх бодлого, үйл ажиллагааны санал боловсрууллаа.</li> <li>Биеийн тамир, спортын улсын хороо, Монголын диф холбоо, Монголын үндэсний паралимпийн холбоо, Монголын тусгай олимпын хороото байгуулсан санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулав.</li> <li>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай байгуулсан санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулав.</li> <li>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим мэдээллийн санг байгуулахтай холбоотойгоор 2022 онд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэх 2 удаагийн уулзалтыг холбогдох байгууллагуудтай хийж, хамтарсан тушаалын төслийг боловсруулав.</li> </ul>			√	
35.	-Кейс шийдвэрлэлтийн талаар нийгмийн ажилтнуудад зориулсан хэрэглээний гарын авлага боловсруулах ажлын удирдамжийг батлууллаа. Энэхүү гарын авлага нь нийгмийн ажилтнуудын арга зүйн туршлагаас суралцах боломжийг нэмэгдүүлэх зорилготой юм. -Эрэгтэйчүүдэд зориулсан нийгэм, сэтгэл зүйн цогц үйлчилгээг тодорхойлох, үйлчилгээний арга зүй, аргачлал боловсруулах ажлын удирдамжийг батлууллаа. Энэхүү арга зүй нь эрэгтэйчүүдэд чиглэсэн нэгдсэн арга зүй, аргачлалын дагуу үйлчилгээ үзүүлдэг байх явдал юм.			√	
36.	“Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их хурлын 2022 оны 01 дугаар тогтоолын тогтоолын 2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор угийн бичгийн хөтлөлтийг үндэсний хэмжээнд сайжруулах, хэвшүүлэх талаар 2022-2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл, 7 дахь заалтын хүрээнд эмэгтэйчүүдэд нөхөн сэргээх, сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэх санал боловсруулах ажил хийгдэж байна.			√	
37.	Хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдийн үндэсний чуулганыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, чуулган зохион байгуулах удирдамжийг ХНХСайдын А/56 дугаар тушаалаар батлуулсаны дагуу хүүхдийн асуудлаар хүлээсэн үүрэг, цаашид хүүхдийн эрх хамгаалах, ээлтэй орчин бүрдүүлэх гарц, шийдлээ тодорхойлох салбарын хэлэлцүүлгүүдийг 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс 04 дүгээр сарын 22-ны өдрүүдэд үе шаттай зохион байгуулав. /ХНХЯ-ны харьяа байгууллагын хэлэлцүүлгийг 05-р сарын 03-нд хийхээр төлөвлөж, бэлтгэл ажлыг хангаж байна./			√	

III	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр				
38.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам түүний харьяа агентлаг, байгууллагуудын эрхлэх асуудлын хүрээнд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.6, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.13-д заасны дагуу нээлттэй болгох өгөгдлийн жагсаалтыг нэгтгэн Цахим хөгжил харилцаа, холбооны яаманд хүргүүлэв.			√	
39.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн бүртгэлийн систем projects.mlsp.gov.mn системийг Дата төв дээр байршуулах ажлыг төслийн зөвлөлтэй хамтран ажиллав. Мөн нээлтийн үйл ажиллагаанд техникийн дэмжлэг үзүүлэн ажиллав.			√	
40.	Яамны цахим хуудсанд дараах өөрчлөлт хийж, мэдээллүүдийг оруулав. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Яамны тухай-Холбоо барих цэсний мэдээллийг шинэчилсэн мөн газар тус бүрээр нь задалж оруулсан.</li> <li>• Мэдээ, мэдээлэл-Ном товхимол цэсэнд Хөдөлмөрийн 21, Нийгмийн хамгааллын 10, Хүн амын салбарын 3 судалгаа, шинжилгээний ажлууд, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ, Хүүхдийн эрхийн стандартын эмхэтгэлийг оруулсан.</li> <li>• Хөдөлмөрийн харилцаа-Хөдөлмөрийн тухай хууль цэсэнд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг даган гарсан журмууд нийт 15 мэдээлэл оруулсан.</li> <li>• Хууль эрх зүй-Засгийн газрын тогтоол цэсний мэдээллийг шинэчлэв.</li> </ul>			√	
41.	Хүүхдийн статистикийн аргачлалыг шинэчлэх ажлын хэсэг 2 удаа хуралдаж, аргачлалын үзүүлэлтүүдийн хүрээг тодорхойлж, үзүүлэлтүүдийн ойлголт, тодорхойлолтыг одоогийн мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн аргачлалын эхний төслийг ҮСХ-ны холбогдох санал, зөвлөмж, дотоод зөвлөхүүдээс ирүүлсэн саналыг тусгаж, аргачлалын төсөл, танилцуулга, мэдээлэл бэлтгэж Сайдын зөвлөлд болон ҮСХ-ны Арга зүйн байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.			√	
42.	Залуучуудын статистикийн маягт шинэчлэх ажлын хүрээнд ГБХЗХГ-ын мэргэжилтнүүдтэй уулзаж, одоо мөрдөгдөж байгаа маягтын нөхцөл байдал, цаашид шинэ маягыг хэрхэн боловсруулах тухай хэлэлцэж арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлсэн. Мөн шинэчилсэн анхан шатны бүртгэл, нэгдсэн бүртгэлийн, захиргааны маягтууд боловсруулахаар тохирсоны дагуу эхний байдлаар маягтуудыг боловсруулж, ҮСХ-нд хүргүүлээд байна.			√	
43.	Үндэсний статистикийн хорооноос төрийн байгууллагын өгөгдлийн санд ашиглаж байгаа ангилал, код, тайлбарын төсөлд санал авахаар ирүүлснийг судалж, холбогдох агентлаг, яамны газрын албан хаагчидтай уулзаж, санал авч мэдээллийг нэгтгэн ҮСХ-нд хүргүүлэв.			√	
44.	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэх ажлын хэсгийн хуралдаанд оролцсон. Мөн хөдөлмөрийн зах зээлийн шинэ системд тайлангийн хэсэг боловсруулах уулзалт хийж, санал болон мэдээлэл хүргүүлсэн. Профайлыг буюу хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээг боловсруулж байгаа төслийн ажилчидтай 2 удаа уулзаж, хөдөлмөрийн зах зээлийн одоо мөрдөгдөж байгаа маягттай профайлыг уялдуулах болон цаашид шинэ маягт боловсруулах талаар хэлэлцэж, тодорхой санал, мэдээллийг хүргүүлэв.			√	
45.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар УИХ-ын гишүүдэд өгөх гарын авлагын эх бэлтгэв.			√	
46.	Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын "Маягт, заавар батлах тухай" 2006 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 18а/03 дугаар, "Зааврын заалт хүчингүй болгох тухай" 2011 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А50/90 дугаар хамтарсан тушаалыг Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А76/А69 дугаар тушаалаар хүчингүй болсонд тооцсон. Үүнтэй холбогдох арга хэмжээг зохион байгуулж ажиллах талаар Нийгмийн даатгалын ерөнхий газарт албан бичиг хүргүүлэв.			√	
47.	Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн төслийг хэлэлцэх ажлын хэсгийн шинжээчдийн найм дахь удаагийн хуралдааныг 2022 оны 04 дүгээр сарын 04-05-ны өдрүүдэд онлайнаар зохион байгуулав.			√	
48.	Нийгмийн даатгалын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох дүрмийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/73 дугаар тушаалаар батлуулж, Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэв.			√	
49.	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж болон бусад холбогдох хуулийн дагуу даатгуулагчид тэтгэвэр тогтоож, олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч байгаа архивын лавлагааг хуурамчаар үйлдэх, засах зэрэг зөрчлийг арилгах, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг			√	

	эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/76 дугаар тушаалаар батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.				
50.	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж болон бусад холбогдох хуулийн дагуу даатгуулагчид тэтгэвэр тогтоож, олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч байгаа шүүхийн шийдвэрийг хуурамчаар үйлдэх, үндэслэлгүй нотлох баримт өгч шүүхийн шийдвэр гаргуулах зэрэг зөрчлийг арилгах, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын Дээд шүүх, Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Монголын шүүгчдийн холбоонд хамтран ажиллах тухай албан бичиг хүргүүллээ. Энэ ажлын хүрээнд Шүүхийн сахилгын хороо, тус яам болон Нийгмийн даатгалын байгууллагын төлөөллийг оролцуулан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулахаар ажиллаж байна.			√	
51.	Гадаад харилцааны сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Цаг уурын хүнд нөхцөлтэй гэж үзэх гадаад улсын хөгжлийг шинэчлэн батлах тухай” 2022 оны А/32,А/246,А/81 дүгээр хамтарсан тушаалыг шинэчлэн батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах талаар Нийгмийн даатгалын ерөнхий газарт албан бичиг хүргүүлэв.			√	
52.	Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 5/А/04 дүгээр хамтарсан тушаалаар Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтэд зарцуулсан хөрөнгийн тооцоо нийлэх, холбогдох хууль, журамд өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсан. Энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан Ажлын хэсгийн удирдамжийн 2.2-т “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан танилцуулгын хамт Сангийн яаманд хүргүүлэв.			√	
53.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх, хувийн туслах үйлчилгээний туршилтын төслийн үр дүнгийн тайлангийн хэлэлцүүлэгт оролцож, холбогдох чиглэлээр санал солилцов.			√	
54.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А/69 тоот тушаалаар Азийн хөгжлийн банкны “Үр дүнтэй нийгмийн халамжийн системийг чадавхи бэхжүүлэх нь ТТ 9893-МОН” төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Нийгмийн халамжийн нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх зорилгоор “Нийгмийн халамжийн ажилтан болон амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах сургалт”-ын хүрээнд Нийгмийн халамжийн бодлогын шинэчлэлийн талаарх цахим сургалтыг 2022 оны 4 дүгээр сарын 07-08-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад нийслэл, аймаг, дүүргийн халамжийн мэргэжилтнүүд болон Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүд нийт 800 гаруй хүнийг хамрууллаа. Түүнчлэн <ul style="list-style-type: none"> <li>• Нийгмийн халамжийн удирдах ажилтнуудын чадавхи бэхжүүлэх сургалтыг 4 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд онлайн болон танхим хослуулан зохион байгуулав.</li> <li>• ХНХЯ, АХБ-тай хамтран хэрэгжүүлж буй техникийн туслалцааны төслийн үнэлгээний хагас жилийн уулзалт хурлыг 2022 оны 4-р сарын 18-ны өдөр зохион байгуулав.</li> <li>• ХНХЯ, АХБ-тай хамтран хэрэгжүүлж буй техникийн туслалцааны төслийн хүрээнд Дэлхийн банктай хамтран 2022 оны 4-р сарын 20-ны өдөр зөвлөлдөх хурал зохион байгуулав.</li> <li>• НҮБ-ийн Хүүхдийн сантай хамтран зөвлөлдөх уулзалтыг 2022 оны 4-р сарын 21-ний өдөр цахимаар тус тус зохион байгуулав.</li> </ul>			√	
55.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга, Нийгмийн халамжийн хэлтэс/албаны дарга нартай Цахимаар уулзалт хийв.				
56.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон бусад төрлийн асаргааны гэрээний маягтад тусгах саналыг яамны холбогдох газруудаас авч нэгтгэн, шинэчилж байна.			√	

57.	Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг 2022 онд хэрэгжүүлэх, зохион байгуулалтыг хангах ажлын хэсгийг ХНХ-ын сайдын 2022 оны А/47 дугаар тушаалаар байгуулан, Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ХНХ-ын сайд болон Батлан хамгаалахын сайд нараар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.			√	
58.	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5 дахь заалтад бүтээн байгуулалтад шаардлагатай гадаад ажиллах хүчний тоонд хязгаарлалт тавихгүй байх гэж заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагуудад шаардлагатай гадаад ажиллах хүчинд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тухай Засгийн газрын тогтоолын төслийг бэлтгэв.			√	
59.	Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжих Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны барилгын их засвар /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ХНХЯ/202212018 дугаартай тендер шалгаруулалтыг зохион байгуулав. Тендерт 1 аж ахуйн нэгжийн материал ирж, тендерийн үнэлгээгээр шаардлага хангаагүй болно.			√	
60.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн үйл ажиллагаатай танилцаж, цаашид сайжруулах арга хэмжээний тухай танилцуулга бэлтгэж, удирдлагуудад танилцуулав.			√	
61.	Засгийн газрын 2013 оны сурагчийн дүрэмт хувцасны үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ХЭДС-аас Монголын оёдлын нэгдсэн холбоо, үйлдвэрүүдэд олгосон зээлийн эргэн төлөлттэй холбоотой асуудлаар мэдээлэл бэлтгэж, зээлийг эргэн төлүүлэх тухай албан бичгийг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлэв.			√	
62.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, зохицуулалтын шийдвэр гаргахад шинжлэх ухааны үндэслэлтэй тооцооллыг ашиглах зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийн системийн динамик загварыг хөгжүүлж үйл ажиллагаандаа ашиглахад бэлэн болоод байна. Системийн динамик загварыг Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллагын дэмжлэгтэйгээр “Системийн динамик загварчлал” ТББ-ын зөвлөх баг боловсруулж, ХНХСИ-ийн удирдлага, ажилтнуудад уг загвараар тооцсон зарим туршилтын үр дүнг танилцуулан, загварыг хүлээлгэн өгөх арга хэмжээг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулав.			√	
63.	Хөдөлмөр эрхлэлтийн системийн динамик загварыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс уг загварыг хөгжүүлсэн зөвлөх багтай хамтран ажиллан хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын статистик тоон мэдээлэл болон загварын тооцооллын нарийвчлалыг сайжруулахаар ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд хөгжүүлэлтийн ажлыг хийх институтын эрдэм шинжилгээний ажилтнуудад зориулсан сургалтыг “Системийн динамик загварчлал” ТББ-тай хамтран 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр зохион байгууллаа.			√	
64.	Монгол Улсын Засгийн газар болон Европын Холбоо хооронд байгуулсан Санхүүжилтийн хэлэлцээр (АСА/2019/42187)-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор хэлэлцээрт заасан шалгуур үзүүлэлтийн биелэлтийг хангах Ажлын хэсгийн хурлыг зохион байгууллаа. Хурлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг төлөөлж Ажлын хэсгийн ахлагч бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Боловсрол, шинжлэх ухааны яамыг төлөөлж Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, НҮБХХ-ийн төслийн зөвлөх Ч.Тунгалаг, Европын Холбоог төлөөлж Европын Холбооноос Монгол Улсад суугаа төлөөлөгчийн газрын төслийн менежер Э.Болор, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн зөвлөх Г.Ганзориг нар Монгол Улсын Засгийн газар, Европын Холбооны хооронд байгуулсан санхүүжилтийн гэрээнд орсон өөрчлөлтийг танилцуулж, төсвийн дэмжлэгийн хувьсах 7 шалгуур үзүүлэлтийг хангах ажлын явц, тулгарч буй бэрхшээлүүд, цаашид анхаарах асуудлуудын талаар хэлэлцлээ.			√	
65.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүн амын сангийн хэрэгжүүлж буй “Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд бэлэн байдлыг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 17-ны өдрүүдэд Завхан аймагт малчдын зөвлөгөөнд оролцон, төслийн үйл ажиллагаатай танилцлаа.			√	
66.	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр ашиглагдаж буй цахим системүүдийг цаашид хэрхэн сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан байна			√	



67.	Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт”-ийг нэвтрүүлэх нь төслийн хүрээнд ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, ажлын хэсгийн гишүүд 2022.04.20-ны өдөр төслийн Олон Улсын болон дотоодын зөвлөхтэй уулзав.			√	
68.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг олгохтой холбоотойгоор Монгол банк, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох албан тушаалтантай уулзалт зохион байгуулав.			√	
69.	-“Тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд 2022-2023 онд хэрэгжүүлэх “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” “ажил хайгч, ажилгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг үнэлэх, хөдөлмөр эрхлэлтийн төлөвлөгөө боловсруулах” аргагүйн сургалтыг 2022 оны 04 сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулав. -Монгол Улсын төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээнд Европын холбооны ихэнх орнуудын хөдөлмөр эрхлэлтийн салбарт хэрэглэдэг “Профайлинг”-ийн аргачлалыг нэвтрүүлж байгаа бөгөөд сургалтын гол зорилго нь холбогдох аргачлалыг оролцогчдод танилцуулж, арга зүйгээр хангасан явдал юм. Профайлинг бол иргэний ур чадвар, хандлага, нөөц бололцоо, хөгжүүлэх шаардлагатай талуудыг тодорхойлоход дэлхийн олон улсын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд түгээмэл ашигладаг арга юм.			√	
70.	“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэг хөгжүүлэх, И-жоб платформыг нэвтрүүлэх ажлын хэсгийн уулзалтыг 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулав. Уулзалтаар И-жоб платформын ажлын явц болон, Мэдээллийн технологийн олон улсын зөвлөх Ашиш Жошигийн өгсөн зөвлөмжтэй танилцаж, цаашид авах арга хэмжээний талаар нээлттэй ярилцав. Уулзалтын бэлтгэл ажлыг хангаж, хурлын тэмдэглэл хөтлөн, хэвлэлийн мэдээллийг бэлтгэж, сайтад байршуулав.			√	
71.	“Монголын эдийн засгийн чуулган-2022” арга хэмжээнд тус яамнаас “Ажиллах хүч ба ажлын байрны ирээдүй” сэдвийн хүрээнд салбар хуралдааныг зохион байгуулахад оролцож, уулзалтаас гарсан тэмдэглэлийг Эдийн засгийн хөгжлийн яаманд 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 01/1039 тоо албан бичгээр англи орчуулгын хамт хүргүүлэв. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтооллын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийн 3.1 заасан хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнд хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ профайлинг хийхтэй холбогдуулан мэргэжилтнүүдийг оролцуулсан уулзалтыг зохион байгуулав. Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүдийн тоон мэдээллийг нэгтгэн 2022 оны 03 дугаар сарын байдлаар гаргав.			√	
72.	Азийн хөгжлийн банкнаас төсвийн дэмжлэгийн зориулалтаар зээл авах хүсэлтийг судалж, “Мөчлөг сөрсөн хөгжлийн санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн хүрээнд 2022 онд батлагдсан төсвийн хүрээнд авсан арга хэмжээ болон бусад холбогдох мэдээллийг нэгтгэн боловсруулав.			√	
73.	“Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай” конвенцын Засгийн газрын ээлжит 10 дахь удаагийн тайланг нэгдсэн үндэсний байгууллагын “Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгах хороо”-оор хэлэлцүүлэх зорилгоор холбогдох мэдээллийг нэгтгэн боловсруулав.			√	
74.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-2022 арга хэмжээг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эерэг соёлыг хамтдаа төлөвшүүлье” уриан дор зохион байгуулахаар 04 дүгээр сарын 01-ний өдөр 21 аймаг, 9 дүүрэгт нэгэн зэрэг нээж эхлүүлээд байна. Уг арга хэмжээний хүрээнд тусгайлсан төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.			√	
75.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах талаар аж ахуйн нэгж, байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, идэвхи, санаачлагыг дэмжих, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах ажлыг 2012 оноос эхлэн 11 дэх жилдээ зохион байгуулав. Ингэхдээ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/64 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах журмын дагуу дараах 4 багц үзүүлэлтээр шалгарууллаа. Үүнд: -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт, -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, тэргүүн туршлага,			√	

	-Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламж, машин механизм, тоног төхөөрөмжийн болон бусад шаардлага, стандарт, -Ажилтны эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээ.				
76.	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2022” арга хэмжээний хүрээнд удирдлагуудаас хийж байгаа мэдээлэл, танилцуулгыг тухай бүр бэлтгэв. Мөн МҮЭХ-ноос эрхлэн гаргадаг хэвлэлд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаарх ярилцлага хийх мэдээллийг бэлтгэж хүргүүлэв.			√	
77.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/74 дүгээр тушаалаар батлагдсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тариф”-ыг шинэчлэн боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/75 дугаар тушаалаар “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үнэлгээ хийх жишиг үнэ”-ийг батлав.			√	
78.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас малчдын хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн аюулгүй байдал болон нийгмийн баталгааг сайжруулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээллийг УИХ-ын нийгмийн бодлогын байнгын хороонд хүргүүлэв.		√		
79.	“Геоземи, зураг зүйн үйлдвэрлэлд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм” /БНД 11-12-20/ барилгын норм, дүрмийн төсөлд холбогдох саналыг боловсруулан Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлэв.			√	
80.	Төрийн албаны ангилал, зэрэглэл, цалин хөлсний тогтолцоог шинэчлэх талаар санал, танилцуулга бэлтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулав.		√		
81.	Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын Дөрөв дэх хэсгээр зохицуулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллын журам”-д багш нарын ажлыг гүйцэтгэлтэй нь уялдуулан өөрчилж, холбогдох Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдуудаас санал авахаар хүргүүлэв.			√	
82.	“Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 107 дугаар тогтоолоор боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёлын салбарын төрийн үйлчилгээний болон бусад төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг тогтоосон. Энэхүү тогтоол хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нь олгодог нэг удаагийн буцалтгүй тусламжийг аль үндсэн цалингаас нь тооцож олгох асуудлыг тодорхой зохицуулах шаардлагатай байгаа тул Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдуудаас санал авахаар хүргүүлэв.			√	
83.	“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоолын 1-ийн 2 дахь хэсэгт “шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын үндсэн цалингийн хэмжээг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хоёр дахин нэмэгдүүлэх арга хэмжээ авах”-ыг Засгийн газарт даалгасантай холбоотойгоор Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлэв.		√		
84.	“Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 275 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлэв.		√		
85.	Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэх зорилгоор боловсруулсан ажлын байрыг онооны аргаар үнэлэх аргачлалын төслийг боловсруулан яамдуудаас санал авахаар хүргүүлэв.			√	
86.	Монгол Улсын Засгийн газраас нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын 2022 оны улсын төсвийн тодотголын төслийг боловсруулж байгаатай холбоотойгоор төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх тооцоо, судалгааг хийж холбогдох хууль тогтоомжийн төслийн хамт Сангийн яаманд хүргүүлэв.			√	
87.	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасан “Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын дүрэм”-ийг Засгийн газрын 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 153 дугаар тогтоолоор батлуулав.		√		

88.	“Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам”-ын төслийг Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагууд болон зарим аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөлд танилцуулах хэлэлцүүлэг зохион байгууллаа. Мөн тус журмын төсөлд санал авахаар яамдуудад хүргүүлэв.			√	
89.	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 147.3-т заасны дагуу “Хөдөлмөрийн сонирхлын маргааныг хөдөлмөрийн зуучлагчийн дэмжлэгтэйгээр зохицуулах журам”, “Хөдөлмөрийн арбитрын дүрэм”-ийг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан санал авахаар бүх яамдууд болон Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын Ажил олгогч эздийн холбоонд хүргүүлэв.			√	
90.	ХНХ-ын дэд сайдаар ахлуулсан “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт-08-ын өнөөгийн нөхцөл байдлыг судлан, сайжруулан боловсронгуй болгох талаар санал боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг 4 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгууллаа. Ажлын хэсгийн хүрээнд дотоодын зөвлөхийг 3 сарын хугацаатай ажиллуулан, YAMAT-08-ын ажил, мэргэжлийн ангиллыг ISCO-08-тай тулган хянах ажлыг гүйцэтгүүллээ. Үндсэн, дэд, бага, нэгж гэсэн бүх бүлгийн ажил мэргэжлийн нэршил, нэр томъёогоор санал боловсруулсан. Нэр томъёоны санал нь цаашид YAMAT-08-д ажил, мэргэжил шинээр нэмэх, өөрчлөх, засварлахад чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн YAMAT-08-д ажил мэргэжил шинээр нэмж оруулах, ямар нэг хэмжээгээр өөрчлөхөд анхаарах асуудал, баримтлах арга зүйн зөвлөмжийг гаргасан. Салбарын яам, мэргэжлийн холбоод, сонирхогч байгууллагуудад YAMAT-08-д ажил, мэргэжил нэмэх, өөрчлөх, засварлахад анхаарах асуудлаар энэхүү зөвлөмжийг хүргэж байна. Ажлын хэсгийн 2022 оны 4 сарын 12-ны хурлаар ажлын хэсэг үндсэн зорилгоо ханган биелүүлсэн гэж үзэн ажлын хэсгийн үйл ажиллагааг хаасан.			√	
91.	YAMAT-08-д 2017-2021 онд 548 ажил, мэргэжлээр орсон засвар, нэмэлт өөрчлөлтийг <a href="http://www.yamat.mlsp.gov.mn">www.yamat.mlsp.gov.mn</a> цахим системд бүрэн оруулж, нийтэд мэдээллээ.			√	
92.	“Хүүхдэд болон гэр бүлд ээлтэй ажлын байрны зохицуулалт Хөдөлмөрийн тухай хуульд” хэлэлцүүлгийг Хүүхдийн сантай хамтран 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт төрийн байгууллага, үйлдвэрчний эвлэлийн байгууллага, ажил олгогч эздийн байгууллага болон аж ахуйн нэгж, байгууллагын хүний нөөцийн ажилтнуудын төлөөлөл 40 гаруй хүн оролцов.			√	
93.	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасан “Насанд хүрээгүй хүнээр ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт” ба “13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл”-ийн төслийг танилцуулж, хэлэлцүүлэх хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хэлэлцүүлгийг 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулав. Хэлэлцүүлэгт холбогдох яамд, төрийн байгууллага, эрдэмтэн судлаач, үйлдвэрчний эвлэлийн байгууллага, ажил олгогч эздийн байгууллагын төлөөлөл 30 гаруй хүн оролцов.			√	
94.	Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн "Эрхийг бодит болгох" Инчеоны стратегийн хэрэгжилтийн тайланг 2022 оны 03 дугаар сард Ази, Номхон далайн бүсийн нийгэм, эдийн засгийн хороонд хүргүүлэхээр тайлан боловсруулах салбар дундын ажлын хэсгийг ХНХС-ын А/24 тоот тушаалаар байгуулан ажлын хэсгийг 3 удаа хуралдуулж, тайланг нэгтгэн хүргүүлэв.			√	
95.	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай ОУ-ын Пактын хэрэгжилтийн Монгол Улсын 5 дугаар илтгэлийг хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг гүйцэтгэх техник ажлын хэсгийн тушаалын төслийг боловсруулав. Техникийн ажлын хэсэг 5-р илтгэлийг хүргүүлснээс хойшхи хугацааны тайлан мэдээллийг боловсруулах юм.			√	
96.	Хүн амын хөгжил, хүн амын өсөлтийг дэмжих хүрээнд ХНХ-ын салбарт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг боловсруулан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэв.			√	
97.	<u>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн чиглэлээр:</u> -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын аймаг, дүүргийн салбар комисс, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл болон холбогдох бусад төрийн үйлчилгээний байгууллагын удирдах ажилтнуудыг чадавхижуулах үндэсний хэмжээний бүсчилсэн сургалтын удирдамж, хөтөлбөр, төсвийг боловсруулж батлуулан Баруун, Хангайн, Төвийн бүсийн сургалтуудыг НҮБ-ын Хүүхдийн сан, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл			√	

	<p>мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах-2” төсөлтэй хамтран зохион байгууллаа.</p> <p>-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхижуулах Улаанбаатар хотын сургалтыг Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах-2” төсөлтэй хамтран зохион байгуулах.</p> <p>-Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх, хувийн туслах үйлчилгээний туршилтын төслийн үр дүнгийн тайланг холбогдох төр, төрийн бус байгууллагуудад хэлэлцүүлэв.</p> <p>-Баруун болон Хангайн, Төвийн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхижуулах сургалтад оролцож, тус сургалт зохион байгуулагдаж буй аймгууд дахь төрийн байгууллагын 600 гаруй албан хаагчдыг, Барилга, хот байгуулалтын яамны 20 гаруй албан хаагч, нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн хэлтсийн 30 гаруй албан хаагчдыг И-Монголиа академийн 20 гаруй албан хаагчдыг, АШУҮИС-ийн дэргэдэх “Залуучуудын Улаан Загалмай” клубын гишүүдэд болон Орхон аймгийн 450 гаруй удирдлага, албан албан тушаалтнуудыг “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай” сургалтад хамрууллаа.</p>				
98.	<p><u>Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр:</u></p> <p>-“Гамшиг онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал” сэдэвт үндэсний сургалтыг 3 өдөр зохион байгуулж, 21 аймаг, нийслэл 9 дүүргийн 70 хүн хамрагдав.</p> <p>-Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага стандартын хэрэглээг олон нийтэд сурталчлах сургалт, сурталчилгаа, мэдээлэл бүхий 16 төрлийн постер бэлтгэн хэвлүүлэв.</p> <p>-“Хүүхдийн эрхийн стандартын эмхтгэл хэвлүүлж хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага аж ахуй нэгжид түгээж, яамны сайтад мөн байршуулав.</p> <p>-Хүүхэд хамгааллын салбар дундын бүлгийн 2022 оны ажлын төлөвлөгөөг батлуулж ажлын хэсгийн гишүүдэд түгээсэн. /Энэхүү төлөвлөгөөний дагуу бүх халамж, асрамжийн төв, Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төв нийт 57 байгууллагад ариутгал, халдваргүйжлийн багц бэлтгэн түгээх бэлтгэл ажлыг зохион байгуулж, нийслэлийн 31 байгууллагатай уулзалт хийж, орон нутгийн 26 байгууллагад Монгол шуудангаар багц түгээв.</p> <p>-Эрчим хүчний яаманд “Олон улсын хүүхдийн Найрамдал-2” зусланг байгуулахад шаардагдах цахилгааны тооцооллыг гаргаж, техникийн нөхцөл олгох хүсэлтийг хүргүүлэв.</p> <p>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/09 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны хуралдаанаар “Олон улсын хүүхдийн Найрамдал зуслан”-ийн их засвар, шинэчлэлийн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан компаниудад гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлэв.</p> <p>-Хүүхдийн үзэл бодол, авьяас чадвар, илэрхийлэмжээр дамжуулан Монгол хүүхдийн урлаг спорт, ур чадвар, оюун санааны хөгжлийг нийгэмд таниулах чиглэлээр нэвтрүүлэг хийх, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр “Хамтран ажиллах тухай” гэрээг С1 телевизтэй байгуулан ажиллаж байна.</p>			√	